

ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ ОНӨААТҮГ-ЫН ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

2025 оны 12 дугаар сарын 23

Улаанбаатар хот

Д/д	Байгууллагын стратегийн зорилт, зорилго тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн	Төсөв (мян төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1.1	Арга хэмжээ:1.1. Нийтийн тээврийн чиглэлийн давхцалыг арилгах, оновчтой төлөвлөх саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ. Алсын хараа-2050-9.3.13, НХТЖҮЧ-9.21.1.	-	Нийтийн тээврийн чиглэлийн давхцалыг бууруулах саналын тоо	1	1	Нийтийн тээврийн бодлогын газраас гүйцэтгэлд суурилсан үнэлгээ буюу KPI нэвтрүүлэхэд аж ахуйн нэгж байгууллагуудаас санал авахаар ирүүлсэн бичгийн хариуд: Ч:7, М:3 чиглэлийн маршрутад өөрчлөлт оруулах санал хүргүүлж, Ч:7А, М:3А чиглэл шинээр нэмэгдүүлэн давхцаж үйлчилдэг 7 тээврийн хэрэгслийн тоог бууруулсан. Мөн чиглэлийн давхцалтай АТ:4 буюу "Нисэх-5 шар-Гандан-ХӨСҮТ" чиглэлийг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 06/323 дугаартай албан бичгээр зогсоох тухай саналыг Нийтийн тээврийн бодлогын газарт хүргүүлсэн. Сургуулийн зориулалттай 8ш автобусаар 7 сургуулийн 900 гаруй сурагчдад техникийн бүхэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг хангуулан үйлчилж байна.	100%
1.2	Арга хэмжээ:1.2. Зорчигч тээврийн урсгалаас хамаарч дагуул, хаяа хот, тосгод нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. Алсын хараа-2050-9.3.20, НХТЖҮЧ-9.21.2.	-	Чиглэлийн тоо	1	2	Зорчигч урсгалаас хамаарч Х:7 буюу Яармагийн 3-Туул тосгон чиглэлд эцсийн буудлыг сунгах санал хүргүүлж, Туул тосгон-Хангарди ордон болгож өөрчилсөн. Мөн Х:7 чиглэлд 6 тээврийн хэрэгсэл үйлчилж байсныг зорчигчдын хүлээлгийг багасгах зорилгоор гаралтын тоог 2-оор нэмэгдүүлж 8ш тээврийн хэрэгслээр шуурхай үйлчлэн ажиллаж байна. Х:6 буюу Өлзийт-Нисэхийн Тойрог-Яармаг 3 дугаар буудал чиглэлийн	100%

1	2	3	4	5	6	7	8
						эцсийн зогсоолын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр судалгаа боловсруулж саналыг Нийтийн тээврийн бодлогын газарт хүргүүлсэн.	
1.3	Арга хэмжээ:1.3. Нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээний чиглэл, сүлжээ, эгнээг оновчтой төлөвлөн эрэлтэд нийцсэн нийтийн тээвэр, зорчих зогсоолыг хөгжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлнэ. НЗДҮАХ-1.5.1.	-	Нийтийн тээврийн чиглэл, сүлжээ төлөвлөлтөд өгсөн саналын тоо.	1	2	Сул зогсолт их гардаг, авто замын ачааллыг нэмэгдүүлдэг “Хангарди цогцолбор”, “Нисэхийн дэнж”, “Нисэхийн эцэс”-ийн зогсоолуудад хяналт шалгалтын хуваарь гарган, 4 шалгагчийг шугам замд өдөр тутам тогтмол ажиллуулж ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлсэн.	100%
1.4	Арга хэмжээ:1.4. Нийтийн тээврийн хэрэгслийн дундын болон эцсийн зогсоолын аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх болон удирдлага, хяналтыг дэвшилтэт техник технологи ашиглан сайжруулах, салбарын чадавхыг бэхжүүлнэ. НЗДҮАХ-1.5.2.	-	Нийтийн тээврийн дундын болон эцсийн зогсоолын чанар хүртээмжийг сайжруулах талаар дээд газарт хүргүүлсэн саналын тоо.	-	1	Х:6 Чиглэлийн судалгааг 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр стандарт хангахгүй эцсийн автобусны зогсоолыг зургаар баримтжуулан саналыг Нийтийн тээврийн бодлогын газарт хүргүүлсэн. Мөн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Х:7 чиглэлийн автобусны зогсоолын нэршил, координатыг судлан зургийг хавсарган судалгааг хүргүүлэн зөрүүтэй тэмдэглэгдсэн зогсоолуудыг бүрэн засварлуулж ажилласан. Ү:31, Ч:79 чиглэлүүдийн эцсийн зогсоолын нөхцөл байдлын талаар дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах хүсэлтийг Нийтийн тээврийн бодлогын газарт 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/05/142 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Удирдлага мэдээллийн болон цахим төлбөрийн системд удаан зогссон тээврийн хэрэгслүүдийг онлайн камерын тусламжтайгаар илрүүлж шаардлага тавьж хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлж, ажлын үр дүнг дээшлүүлж ажилласан. Цагдаагийн байгууллагаас 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш нийт	100%

1	2	3	4	5	6	7	8
						автобусны камер шүүлгэх 5 албан бичиг ирүүлсэний дагуу шүүж бичлэгийг хүргүүлж ажилласан.	
1.5	Арга хэмжээ:1.5. Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийн хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. Алсын хараа-2050-9.3.11, НХТЖҮЧ-9.22.1	-	Өдөрт үйлчилгээнд гарах тээврийн хэрэгслийн тоо	105	115	Нийслэлийн Засаг Даргын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/274 дүгээр захирамжийн дагуу "Зорчигч тээвэр дөрөв" ОНӨААТҮГ-аас YUTONG маркийн 10 автобусыг хувийн хэвшлийн 2 компанид шилжүүлэн өгч нийслэлээс ирүүлсэн шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар парк шинэчлэлтээр орж ирж манай байгууллагад хуваарилагдсан 95 автобусны онлайн хяналтын камер суурилуулж нэгдсэн удирдлагад бүрэн холбогдон ажиллаж байна.	100%
1.6	Арга хэмжээ 1.6. Нийтийн тээврийн хэрэгслээр тэргэнцэртэй иргэн зорчих хүртээмжийг дээшлүүлнэ. НХТЖҮЧ-9.21.3.	-	Арга хэмжээний тоо	-	2	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан нийт 600 ширхэг YUTONG автобусаас тус байгууллага 95 тээврийн хэрэгслээр нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлж байна. Эдгээр автобуснууд тэргэнцэртэй иргэдэд үйлчлэх боломжтой байдлаар тоноглогдсон ба байгууллагын зүгээс жолооч нарт тэргэнцэртэй иргэнд хэрхэн үйлчлэх талаар сургалтыг зохион байгуулсан.	100%
1.7	Арга хэмжээ:1.7. Байгууллагын чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлнэ. НЗДҮАХ-1.5.2, НХТ-2025-5.335	Дотоод эх үүсвэр	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100%	Ажил үүргийн давхардлыг арилгах оновчтой хуваарилалт хийж байгууллагын шинэчилсэн бүтцийг захирлын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар батлуулсан.	100%
1.8	Арга хэмжээ:1.8. MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. НЗДҮАХ-1.5.2, НХТ-2025-5.337	Дотоод эх үүсвэр	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	100%	MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна.	30%

1	2	3	4	5	6	7	8
3.6	Арга хэмжээ:3.6. Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтээс өөрийн байгууллагын хариуцах 27, 47 дугаар индексийн үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангах.	-	Хотын хөгжлийн индексийн хэрэгжилтийн хувь	87,4%	90%	Тус байгууллага нь нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор жолооч нарыг 6 хэсэгт хуваан Нийтийн тээврийн газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/42 тушаалаар батлагдсан "Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системээр нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэлийг тооцох аргачлал"-ыг жолооч нарт танилцуулан ашиглалттай холбоотой зөрчлүүдийг эрс бууруулж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн ажилласан.	100%
3.9	Арга хэмжээ:3.9. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага UCS1603B:2022 стандарт хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Стандарт хэрэгжилтийн хувь	90%	95%	Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний 14 чиглэлд ажлын өдөр 95, амралтын өдөр 83 автобусаар тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангаж, техникийн бэлэн байдлын коэффициентийг 98.6 хувьтай ажиллаж байна.	98%
ДУНДАЖ БИЕЛЭЛТ							96.1%

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Н.ДААРИЙМАА

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ц.ТОГТОХБУЯН